



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/291

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 27 дугаар хорооны
“Андсайхан” өрхийн эрүүл мэндийн
төвийн балансаас барилга хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 190 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/781 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баянзүрх дүүргийн 27 дугаар хорооны өрхийн эрүүл мэндийн төвийн балансад бүртгэлтэй 25,915,900 /хорин таван сая есөн зуун арван таван мянга есөн зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилгыг данс бүртгэлээсээ хасахыг Баянзүрх дүүргийн 27 дугаар хорооны “Андсайхан” өрхийн эрүүл мэндийн төв /Н.Элбэгзаяа/-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг “Андсайхан” өрхийн эрүүл мэндийн төв /Н.Элбэгзаяа/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ